



МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР  
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2026 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/НО

Улаанбаатар хот

Шинжлэх ухааны байгууллагуудын төрийн  
үйлчилгээний албан хаагчийн цалингийн  
доод хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн "Шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 224 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинжлэх ухааны байгууллагуудын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаалын хэрэгжилтэд мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (Б.Отгонцэцэг)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД БӨГӨӨД  
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД



Ж.ЭНХБАЯР

152601000045



Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/ дугаар тушаалын хавсралт 110



ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаал	Цалингийн хэмжээ
ТҮШУ-7	2,746,200
ТҮШУ-6	2,075,750
ТҮШУ-5	1,975,700
ТҮШУ-4	1,882,550
ТҮШУ-3	1,792,850
ТҮШУ-2	1,706,600
ТҮШУ-1	1,475,450